



ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/147

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 9 дүгээр зүйлийн 9.4, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үйлчлүүлэгч, ажилтнуудад ээлтэй орчин бүрдүүлэх, ногоон байгууламж бий болгох зорилгоор “Ногоон орчин-хөгжлийн гарц” болзолт уралдааныг 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийг дуустал зохион байгуулсугай.

2. Болзолт уралдааныг дүгнэх комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга:	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил, мэдээллийн технологи эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	Ш.Сугармаа	Хүний нөөцийн мэргэжилтэн
Гишүүд:	О.Оюунтөгс	Сувилахуйн албаны дарга
	С.Ариунболд	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн
	Л.Мөнхгэрэл	Эрүүл ахуйч бага эмч

3. Албад, поликлиник, клиникүүд, тасгууд, багуудын эрхлэгч, ахлагч нар өөрсдийн хариуцсан талбайгаа зүлэгжүүлэх, мод тарих, байнга услах, шинэлэг орчны тохижилт хийж, цэвэр цэмцгэр байлгахад онцгойлон анхаарч ажиллахыг үүрэг болгосугай.

4. Болзолт уралдааныг дүгнэх журмыг боловсруулан мөрдөж ажиллахыг Комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

000360

5. Болзолт уралдааны тэргүүн байранд өргөмжлөл, 800,000 /найман зуун мянга/ төгрөг, дэд байранд өргөмжлөл, 500,000 /таван зуун мянга/ төгрөг, тусгай байранд өргөмжлөл, 300,000 /гурван зуун мянга/ төгрөг, “Шилдэг бүтээлч ажилтан” өргөмжлөл, 200,000 /хоёр зуун мянга/ төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсугай.

6. Болзолт уралдаанд зарцуулах 1,800,000 /нэг сая найман зуун мянга/ төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү бүртгэлийн албаны дарга, ахлах нягтлан бодогч /Н.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Л.НАСАНЦЭНГЭЛ